

**БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГЫН ЧАНАР,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Б.БАЯРДУЛАМЫН
2025 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
5.1. Барилга, барилгын материалын салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд:							
5.1.1	Арга хэмжээ № 5.1.1.1 Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд санал авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулна. /ЗГҮАХХАХТ-ний 4.2.4.3.1286/	Хуулийн үзэл баримтлалын төсөл, тоо-1	Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөл	Үзэл баримтлалын төслийг боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлнэ.	Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал боловсруулах, батлуулах хүртэлх холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг ХББОСС-ын 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 210, 10 дугаар сарын 17-ны өдрийн 228 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг нийт 6 удаа хуралдаж үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/4714 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	2025.12.25	100 ✓



5.1.4	<p>Арга хэмжээ № 5.1.4.1. Барилга байгууламжийн газар хөдлөлт, тэсвэрлэлтийг хангах ажлыг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.</p>	Хийгдсэн судалгаа, тоо-1,	Орчуулсан хууль /Япон Улсын хууль/	Төслийн хувилбар боловсруулсан байна.	<p>Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Барилга байгууламжийн газар хөдлөлт, тэсвэрлэлтийг хангах анхдагч хуулийн хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажилласан. Төслийн ахлагч К.Овада, барилгын хүчитгэлийн инженер С.Фүкүшима, төслийн ажилтан Д.Эрдэнэбат, С.Пүрэвдорж нартай 2025 оны 8 дугаар сарын 05-наас 12 дугаар сарын 12-ны хооронд нийт 6 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажиллалаа. Тус яамны зүгээс "Барилгын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн үйл ажиллагааны талаар зүйл заалтаар оруулахаар шийдвэрлэж хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 11 дүгээр бүлэгт тусгасан.</p>	2025.12.25	100 ✓
5.5. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, газар хөдлөлтийн чиглэлээр норм, дүрэм, журмыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:							
5.5.1	<p>Арга хэмжээ № 5.5.1.1 Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	Геопортал цахим систем	Суурь судалгаа хийгдсэн.	Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал тайлан хянаж, холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.	<p>Олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлж геопорталд байршуулахын тулд дараах ажлуудыг зохион байгууллаа. Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн газар хөдлөлийн аюулын үнэлгээ ба бичил мужлалын судалгаа, зураглалыг "Инженер геологи, геотехник, барилга бүтээц, газар хөдлөлтийн арга хэмжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэхээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025.11.12-ны өдрийн 07/4197 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцэн, дэмжсэн шийдвэр гарсан.</p> <p>Мөн Шинжлэх ухааны академийн физик, математик, информатикийн салбарын бага чуулганы 2025.12.03-ны өдрийн хурлаар дээрх аймгуудын судалгааны тайланг хэлэлцэж,</p>	2025.12.25	90 ✓

					зорилтоо биелүүлсэн гэсэн шийдвэр гарсан байна. 2026 оны 01 дүгээр сарын ХББОСЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-р хэлэлцүүлж, хэрэглээнд 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэхээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.		
5.5.2	Арга хэмжээ № 5.5.2.1 Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын төсвийг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлсэн байна.	Санхүүжилтийн санал, тоо - 1	14 аймгийн бичил мужлалын зургийн судалгааны ажил хийгдсэн.	Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын төсвийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны төлөвлөгөөний 53 дугаарт Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх ажлыг тусгуулж, батлуулсан. Гэрээг сунгахтай холбогдуулан Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал, төслийн удирдагч Ч.Одонбаатар, тус хүрээлэнгийн Газар хөдлөлтийн аюулын үнэлгээний лабораторийн эрхлэгч М.Дэмбэрэлдулам, яамны санхүү Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Ж.Орхонбаяр, Барилгын чанар, аюулгүй байдлын бодлого, зохицуулалт харицсан ахлах шинжээч Б.Баярдулам нарыг оролцуулан 2025.10.22-ны өдөр хуралдсан. Хурлаас Өмнөговь, Хөвсгөл аймгуудын газар хөдлөлийн бичил мужлалын зураглалын ажлын тайланг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, шинээр хийх 2 аймгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэр гарсан. Нэмэлт гэрээний төсөл, хурлын тэмдэглэл боловсруулан холбогдох материалыг бүрдүүлэн ТЗУГ-ийн Хуулийн хэлтсээр хянуулахад сунгах боломжтой дүгнэлт гаргасан. 2025 оны 12 дугаар сарын 04-ны өдөр ТНБД-аар хянуулахад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй, шинээр худалдан авах ажиллагааг зарлах чиглэл өгсөн. Үүний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна.	2025.12.25	80 ✓

5.5.3	<p>Арга хэмжээ № 5.5.3.1 Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлэх талаарх саналыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/</p>	Арга хэмжээний тоо	999 барилга байгууламжийг паспорт жуулсан.	Тулгамдаж буй асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах ажлыг зохион байгуулна.	Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх "Барилгын хүчитгэлийн үйл ажиллагааны урт хугацааны төлөвлөгөө (2025-2034)"-ний төсөлд холбогдох саналыг тусгуулахаар 2025.12.18-ны өдрийн 01/4729 дугаар бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Японы улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төслийн багтай хамтран 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 12-ны хооронд 3 удаа уулзалт зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах төсөл дээр хамтран ажилласан болно.	2025.12.25	80 
5.5.4	<p>Арга хэмжээ № 5.5.4.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт барилга байгууламжийн паспортжуулах ажлын төсвийг тусгуулах, холбогдох сургалтыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/</p>	Сургалт, тоо – 1	3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	Сургалт зохион байгуулна.	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах болон сургууль, цэцэрлэгийн барилгуудыг газар хөдлөлтийн гамшгийн үед хоргодох байраар ашиглахад арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхижуулах цахим сургалтыг 2025.12.03-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын болон хяналтын хэлтсийн 45 гаруй албан хаагчид хамрагдлаа. Сургалтын явцад аймгийн хэмжээнд одоо ашиглагдаж буй барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг шалгах багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тухайн жилийнхээ төсвийн 1-ээс дээш хувийг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа барилга байгууламжийг паспортжуулах ажилд тусган хамтран ажиллах тухай 2025.11.27-ны өдрийн 01/4357 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.	2025.12.25	100 

5.5.5	<p>Арга хэмжээ № 5.5.5.1 Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл"-ийн биелэлтийг хангуулна.</p>	Биелэлтийн тайлан, тоо - 1	Төлөвлөгөөний төсөл боловсруулагдсан.	Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж төлөвлөгөөний биелэлтийг гаргана.	<p>Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий "Байнгын ажиллагаатай дэд зөвлөл"-ийн 2025 оны ээлжит хуралдаанд 10 дугаар сарын 10-ны өдөр ББМБЗГ-ын дарга Д.Энхбаатарын хамт оролцсон.</p> <p>"Байнгын ажиллагаатай дэд зөвлөл"-ийн 2025 оны үйл ажиллаганы төлөвлөгөөний биелэлт, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/4144 дугаартай бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.</p> <p>"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн III үе шатны (2026-3030) арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгээс боловсруулсан төлөвлөгөөний төсөлд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах талаар саналыг ажлын хэсгийн гишүүн ХБОСБЗГ-ийн мэргэжилтэн Э.Дашцэрэнд 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр цахимаар хүргүүлсэн.</p>	2025.12.25	100 ✓
-------	--	----------------------------	---------------------------------------	---	--	------------	----------

5.5.6	<p>Арга хэмжээ № 5.5.6.1 Газар хөдлөлтийн албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Нэгтгэсэн тайлан, тоо-1</p>	<p>БХБС-ын 2023 оны 01 дүгээр албан даалга вар батлагд сан.</p>	<p>Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хэмжээ ажиллана.</p> <p>арга авч</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайдын хуучнаар/ "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2023/01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай 2025.09.16-ны өдрийн 07/3445 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн. Барилгын 2025.11.07-ны өдрийн 01/3120 дугаартай бичгээр Архангай, Увс, Баянхонгор, Дундговь, Баян-Өлгий аймгийн хэмжээнд ашиглаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн судалгааг ирүүлсэн. Уг судалгааны нэгтгэлээр паспортжуулах шаардлагатай болон буулгаж шинээр барих шаардлагатай барилга байгууламжийн нэгдсэн тоо гарсан. Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрийн төсөвтөө тусгахгүй, нэгдсэн шалгалт хийж хэрэгжүүлэхгүй нийтлэг байдалтай байна. Үүнтэй уялдуулан 21 аймгийн Засаг дарга нарт барилга байгууламжийн паспортжуулалтын ажилд 2026 онд авах арга хэмжээний санал ирүүлэх, хамтран ажиллах тухай 2025.11.27-ны өдрийн 01/4357 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд шинээр 1, шинэчилсэн 3 буюу нийт 4 барилгын дүрмийг боловсруулж, батлуулан ажиллалаа.</p>	2025.12.30	100 ✓
5.5.13	<p>Арга хэмжээ № 5.5.13.1 Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл 2 дугаар үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</p>	<p>Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан -1</p>	<p>Төсөл хэрэгжиж эхэлсэн.</p>	<p>Барилга байгууламжийн хүчитгэх норм, дүрэм, зургийг боловсруулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Онцгой байдлын ерөнхий газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ хамтран "Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд боловсруулсан "Гамшгийн үед түр байраар ашиглах сургууль, цэцэрлэгийн төлөвлөлтийн гарын авлага", "Газар хөдлөлт тэсвэрлэлтийг хангах барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах заавар"-ыг ХББОСС-ын 2025</p>	2025.12.30	100 ✓

				оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 238 дугаар тушаалаар батлуулсан. Хэвлэн олшруулах, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 06/4337 дугаартай бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн. Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн төрөх барилгын хүчитгэлийн угсралтын ажил 2025 оны 06 дугаар сараас эхлэн хийгдэж байна.		
Арга хэмжээ № 5.5.13.2 “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-105-18/ шинэчлэн боловсруулна.	Барилгын дүрэм-1	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	Шинэчлэн боловсруулсан “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-105-18/ барилгын дүрмийн төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 261 дүгээр тушаалаар батлуулсан. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 07/4590 дугаартай бичгээр холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.	2025.12.30	100 
Арга хэмжээ № 5.5.13.3 “Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-106-18/ шинэчлэн боловсруулна.	Барилгын дүрэм-1	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	Шинэчлэн боловсруулсан “Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-106-18/ барилгын дүрмийн төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 12	2025.12.30	100 

				дугаар сарын 08-ны өдрийн 262 дугаар тушаалаар батлуулсан. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 07/4590 дугаартай бичгээр холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.		
Арга хэмжээ № 5.5.13.4 “Том хавтгалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-107-18/ шинэчлэн боловсруулна.	Барилгын дүрэм-1	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	Шинэчлэн боловсруулсан “Том хавтгалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-107-18/ барилгын дүрмийн төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 263 дугаар тушаалаар батлуулсан. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 07/4590 дугаартай бичгээр холбогдох баримт бичгийг хүргүүлсэн болно.	2025.12.30	100 ✓
Арга хэмжээ № 5.5.13.5 “Модон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” барилгын дүрмийг шинэчлэн боловсруулна.	Барилгын дүрэм-1	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	“Модон каркасан болон хавтгалжин бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” /БД / барилгын дүрмийн төслийг шинээр боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Редакци, шүүмжийг тусган засварлаж дараагийн Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	2025.12.30	80 ✓
Арга хэмжээ № 5.5.13.6 “Ган бүтээцтэй барилгын газар хөдлөлт	Барилгын дүрэм-1	Холбогдох мэргэж	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын	“Ган бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” /БД 22-108-25/ барилгын дүрэм шинээр	2025.12.30	100 ✓

	тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” барилгын дүрэм шинэчлэн боловсруулна.		лийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	сайдаар батлуулсан байна.	боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлуулсан. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 07/4590 дугаартай бичгээр холбогдох баримт бичгийг хүргүүлсэн.		
5.5.14	Арга хэмжээ № 5.5.14.1 Паспортжуулсан барилга байгууламжид нэгдсэн байдлаар ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулна.	Гэрчилгээ олгосон барилга, тоо	999 барилга байгууламжийн паспорт жуулсан.	Барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулна.	Энэ ажлын хүрээнд 2025 онд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ дараах 4 барилгын паспортжуулалтын дүгнэлт гаргасан. Дурдвал: Төв аймгийн Баянцагаан сумын ерөнхий боловсролын сургууль, Засгийн газрын 12 дугаар байрны барилга /5 блок/, Барилгын хөгжлийн төвийн барилга, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨҮГ-ын төв байр болон соёлын төвийн барилга. Тагнуулын ерөнхий газрын Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах "Ёл хад" нөхөн сэргээх төвийн барилгын паспортжуулатын дүгнэлтийн ажил хийгдэж байна. Мөн Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар Улаанбаатар хотын хэмжээнд 2025 онд 23 барилга байгууламжийг паспортжуулах хөрөнгийг шийдвэрлэж тендерийг зарлаж, Нийт 187.9 сая төгрөгийн санал ирүүлсэн "Ончтэнхлэг" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт олон нийтийн 6 барилга, гал унтраах ангийн 3 барилга, орон сууцны 9 барилга, инженерийн дэд бүтцийн 5 барилга байгууламжийг паспортжуулах ажил хийгдэж байна.	2025.12.30	100

					Дорноговь болон Дундговь аймгуудад шинээр баригдсан 4 барилгад ногоон гэрчилгээ олгогдсон байна.		
5.5.15	Арга хэмжээ № 5.5.15.1 Инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх ба угсрах /БД 34-104-25/ барилгын дүрэм шинэчлэн боловсруулна.	Барилгын норм ба дүрэм -1	Барилга байгууламжийн норм нормативын сангийн 2025 оны төлөвлөгөөнд туссан.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 84 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх ба угсрах" /БНБД 34-104-25/ барилгын норм ба дүрэм гэснийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 203 дугаар тушаалаар барилгын дүрэм /БД 34-104-25/ гэж өөрчлөн батлуулсан. Хэрэгжилтийг хангуулахаар 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 07/3312 дугаартай бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн.	2025.12.30	100 ✓
	Арга хэмжээ № 5.5.15.2 Гадаргын усны үндсэн үзүүлэлтийг тодорхойлох /БНБД 33-10-25/ барилгын норм ба дүрэм шинэчлэн боловсруулна.		Барилга байгууламжийн норм нормативын сангийн 2025 оны төлөвлөгөөнд туссан.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар батлуулсан байна.	"Гадаргын усны үндсэн үзүүлэлтийг тодорхойлох" /БНБД 33-10-25/ барилгын норм, дүрэм шинэчлэн боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 237 дугаар тушаалаар батлуулсан. Барилгын норм, дүрмийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамтай 8-11 дүгээр сарын хооронд нийт 3 удаагийн уулзалт зохион байгуулсан. Энэхүү барилгын норм, дүрмийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 7428 дугаарт бүртгүүлэн 2025 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 4567 дугаар бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн.	2025.12.15	100 ✓
	Арга хэмжээ № 5.5.15.3 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм"	Барилгын норм ба дүрэм -1	ШУТ33Х-р хэлэлцүүлсэн.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-03-04/ барилгын норм, дүрэмд дүн шинжилгээ судалгаа хийж, шинэчлэн боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын	2025.12.15	100 ✓

107

/БНБД 21-03-04/ барилгын норм, дүрэмд дүн шинжилгээ судалгаа хийж, шинэчлэн боловсруулна.			батлуулсан байна.	сайдын 2025 оны 75 дугаар тушаалаар батлуулсан.		
Арга хэмжээ № 5.5.15.4 “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” /БД 31-102-00/ барилгын дүрэм шинэчлэн боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулна.	Ажлын техникийн даалгавар -1	-	Техникийн даалгаврыг батлуулсан байна.	“Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” /БД 31-102-00/ барилгын дүрэм шинэчлэн боловсруулах ажлын техникийн даалгаврыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 12/2025 дугаартай батлуулсан. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ- т 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлсэн. Барилгын хөгжлийн төвийн захирлын 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/499 дугаартай тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зарлан 11 дүгээр сарын 17-ны өдөр нээсэн боловч оролцогч ороогүй байна.	2025.12.15	100 ✓
Арга хэмжээ № 5.5.15.5 “Фидик улаан ном- Барилгын ажлын гэрээний нөхцөл”, “Фидик цагаан ном-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар” баримт бичгийг шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулна.	Ажлын техникийн даалгавар -1	-	Техникийн даалгаврыг батлуулсан байна.	Фидик улаан ном-Барилгын ажлын гэрээний нөхцөл”, “Фидик цагаан ном-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар” баримт бичгийг шинээр боловсруулах ажлын техникийн даалгаврыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 25/2025, 26/2025 дугаартай батлуулан Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 07/4556 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.12.25	100 ✓
Арга хэмжээ № 5.5.15.6 “Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах	Баримт бичгийн төслийн боловсруу	-	Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	“Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар” /БД 31-101-00/ барилгын дүрмийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Инженер геологи, геотехник, барилга бүтээц, газар хөдлөлтийн арга хэмжээний	2025.12.25	100 ✓

аргачилсан заавар" /БД
31-101-00/ шинэчлэн
боловсруулна.

лалт 100%
хүрсэн
байна.

мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцэн
дэмжигдсэн.

Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах

1.	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.	Ирсэн бичиг шийдвэрлэлт /тоогоор/ Төлөвлөгөө ,тайлан /улирлаар, хагас бүтэн жилээр/	-	Сүүлийн хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнана. Ирсэн бичгийг шийдвэрлэнэ.	Газрын Монгол Улсын хөгжлийн жилийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулж, газрын даргаар хянуулан баталгаажуулж 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ХБОСБЗГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны Албан даалгавар (1,2,3,4) -ын хэрэгжилт, Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийн хэрэгжилтийн газрын биелэлтийг нэгтгэн СХШУДАГ-т 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хүргүүлсэн. Төрийн жинхэнэ албан хаагчийн жилийн эцсийн тайланг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 15-нд газрын даргаар үнэлүүлсэн.	2025.08.04 2025.12.30	100
2.	Арга хэмжээ 3.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах.	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тоо	-	Зөрчилгүй ажилласан байна.	Ёс зүй, ашиг сонирхлын зөрчил гаргаагүй.	2025.08.04 2025.12.30	100
3.	Арга хэмжээ №3.5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон	ТАХ-ын ХОМ Бичиг баримт архивлалт Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	-	Бичиг баримт архивт хүлээлгэж өгнө. - Өргөдөл, гомдол шийдвэрлэнэ.	Өмнөговь, Дорнод, Хэнтий аймагт баригдах Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 1 дүгээр үе шатны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Худалдан авах ажиллагаатай баримт бичгийг архивлан Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Ж.Орхонбаярт бүрдүүлж өгсөн. Ирсэн бичиг 23, нийт 19 албан бичгийг хугацаанд хүргүүлж шийдвэрлэсэн. Хугацаа хоцорсон бичиг байхгүй.	2025.08.04 2025.12.30	100

	эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.						
4.	Арга хэмжээ № 3.63. Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагуудаас байгуулсан Ажлын хэсэгт орж чиг үүргийн дагуу холбогдох байгууллагуудын ажлын хэсэгт мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах.		Хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/34 дугаар тушаалаар Өмнөговь, Дорнод, Хэнтий аймагт баригдах Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 210 дугаар тушаалаар байгуулсан Барилгын тухай хууийн ажлын хэсгийн нарийн бичгээр ажиллаж байна. Ажлын хэсэг нийт 6 удаа хуралдаж хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.	2025.08.04 2025.12.30	100
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ний биелэлт							
1.	“Газар хөдлөлтөд тэсвэртэй угсармал хавтгайлжин барилгын бүтээц төсөллөх аргачилсан заавар” шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулах	Ажлын техникийн даалгавар -1		Техникийн даалгаврыг батлуулсан байна.	“Газар хөдлөлтөд тэсвэртэй угсармал хавтгайлжин барилгын бүтээц төсөллөх аргачилсан заавар” баримт бичгийг шинээр боловсруулах ажлын техникийн даалгаврыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 27/2025 дугаартай батлуулан Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 07/4683 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	2025.12.11 2025.12.18	100 ✓
2.	“Том хавтгайлжин барилгын бүтээцийн систем зураг төсөл боловсруулах дүрэм” шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулах	Ажлын техникийн даалгавар -1		Техникийн даалгаврыг батлуулсан байна.	“Том хавтгайлжин барилгын бүтээцийн систем зураг төсөл боловсруулах дүрэм” баримт бичгийг шинээр боловсруулах ажлын техникийн даалгаврыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 28/2025 дугаартай батлуулан Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т	2025.12.11 2025.12.18	100 ✓

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ					2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 07/4683 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		
д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1.	Арга хэмжээ 1. Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байна.	Сургалтын тоо	1	Богино хугацааны сургалтад хамрагдсан байна.	Барилгын хөгжлийн төв зохион байгуулсан барилгын салбарт “Барилгын мэдээлэлтэй загварчлал (BIM) технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаа сэдэвт” сургалт семинарт оролцсон. Гэрчилгээ 25-071.	2025.09.03	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ББМУЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

(Албан тушаал)



(Б.БАЯРДУЛАМ)

(Нэр, гарын үсэг)

2025.12.10

(Огноо)

128

**БАРИЛГЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ Б.БАЯРДУЛАМЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулгдах үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Хот байгуулалтын салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ № 5.1.1.1 Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд санал авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулна. /ЗГҮАХХАХТ-ний 4.2.4.3.1286/	60	10	70	✓
2.	Арга хэмжээ 5.1.4.1 Барилга байгууламжийн газар хөдлөлт, тэсвэрлэлтийг хангах ажлыг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	60	10	70	✓
3.	Арга хэмжээ № 5.5.1.1 Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	60 59	9	69 63	✓
4.	Арга хэмжээ № 5.5.2.1 Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын төсвийг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлсэн байна.	48	8	56	✓
5.	Арга хэмжээ № 5.5.3.1 Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлэх талаарх саналыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/	48	8	56	✓
6.	Арга хэмжээ № 5.5.4.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт барилга байгууламжийн паспортжуулах ажлын төсвийг тусгуулах, холбогдох сургалтыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/	60	10	70	✓
7.	Арга хэмжээ № 5.5.5.1 Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл"-ийн биелэлтийг хангуулна.	60	10	70	✓
8.	Арга хэмжээ № 5.5.6.1 Газар хөдлөлтийн албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	60	10	70	✓
9.	Арга хэмжээ № 5.5.13.1 Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг	60	10	70	✓

	бэхжүүлэх төсөл 2 дугаар үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.				
10.	Арга хэмжээ № 5.5.13.2 “Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-105-18/ шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
11.	Арга хэмжээ № 5.5.13.3 “Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-106-18/ шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
12.	Арга хэмжээ № 5.5.13.4 “Том хавтгалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал” /БД 22-107-18/ шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
13.	Арга хэмжээ №5.5.13.5 “Модон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” барилгын дүрмийг шинэчлэн боловсруулна.	48	8	56	✓
14.	Арга хэмжээ № 5.5.13.6 “Ган бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар” барилгын дүрэм шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
15.	Арга хэмжээ № 5.5.14.1 Паспортжуулсан барилга байгууламжид нэгдсэн байдлаар ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулна.	60	10	70	✓
16.	Арга хэмжээ № 5.5.15.1 Инженерийн шугам сүлжээг хонгилын системд төлөвлөх ба угсрах /БД 34-104-25/ барилгын дүрэм шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
17.	Арга хэмжээ № 5.5.15.2 Гадаргын усны үндсэн үзүүлэлтийг тодорхойлох /БНБД 33-10-25/ барилгын норм ба дүрэм шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
18.	Арга хэмжээ № 5.5.15.3 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах галын аюулгүйн норм” /БНБД 21-03-04/ барилгын норм, дүрэмд дүн шинжилгээ судалгаа хийж, шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
19.	Арга хэмжээ № 5.5.15.4 “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар” /БД 31-102-00/ барилгын дүрэм шинэчлэн боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулна.	60	10	70	✓
20.	Арга хэмжээ № 5.5.15.5 “Фидик улаан ном-Барилгын ажлын гэрээний нөхцөл”, “Фидик цагаан ном-Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар” баримт бичгийг шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулна.	60	10	70	✓
21.	Арга хэмжээ № 5.5.15.6 “Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар” /БД 31-101-00/ шинэчлэн боловсруулна.	60	10	70	✓
22.	“Газар хөдлөлтөд тэсвэртэй угсармал хавтгайлжин барилгын бүтээц төсөллөх аргачилсан заавар” шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулах	60	10	70	✓
23.	“Том хавтгайлжин барилгын бүтээцийн систем зураг төсөл боловсруулах дүрэм” шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулах	60	10	70	✓
Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах					
24.	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.	60	10	70	
25.	Арга хэмжээ 3.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах.	60	10	70	

26.	Арга хэмжээ 3.5. Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж, явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх	60	10	70	
27.	Арга хэмжээ № 3.63. Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагуудаас байгуулсан Ажлын хэсэгт орж чиг үүргийн дагуу холбогдох байгууллагуудын ажлын хэсэгт мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	60	10	70	
Дундаж оноо:				68.4	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байна.	100	15	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо		7

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 68.4 68,2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6.6

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97 96,8

Үнэлгээ өгсөн:

Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга

Д. Энхбаатар

/Д.Энхбаатар/
2025.12./10.

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Барилгын чанар, аюулгүй байдлын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч

Төрийн жинхэнэ албан хаагч:

Б. Баярдулам

/Б.Баярдулам/

2025.12.

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга
Хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч

М. Баяраа

2025.12.

2025.12.

Үнэлгээг баталгаажуулсан:

Төрийн нарийн бичгийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Төсвийн шууд захирагч

М. Баяраа

/М.Баяраа/

2025.12.